



**ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬУЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН  
2021 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН**

## ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН 2021 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАНГИЙН АГУУЛГА:

### Нэг.ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

1.1. Бодлого зорилтыг хангах ажлын хүрээнд .....	3-3
1.2. Тогтоол, шийдвэр, хууль дүрэм, журмын хэрэгжилтийг хангах чиглэлээр:.....	3-3
1.3. Удирдлага, зохион байгуулалтын чиглэлээр: .....	3-3

### Хоёр.ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛЭЭР:

2.1.Хэлтсээс зохион байгуулсан ажил,үйлчилгээ.....	4-7
2.2 Онц байдлын үед авч хэрэгжүүлж буй арга хэмжээ .....	7-8
2.3. Албан хаагчдын ажиллах нөхцөл бололцоо,нийгмийн баталгааг хангах чиглэлээр .....	9-9
2.4. Сонгуулийн арга хэмжээний үеэр авч хэрэгжүүлсэн арга хэмжээ.....	9-10

### Гурав. СУРГАЛТ СУРТАЛЧИЛГААНЫ ЧИГЛЭЛЭЭР

3.1. Ерөнхий газраас зохион байгуулсан сургалтууд:.....	10-13
3.1. Аймаг орон нутгаас зохион байгуулсан сургалтууд .....	13
3.2. Хэлтсээс зохион байгуулсан сургалтууд:.....	13-14

### Дөрөв: ХЭЛТСИЙН МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД, НЭЭЛТТЭЙ БАЙДЛЫГ

<b>ХАНГАХ ЧИГЛЭЛЭЭР</b> .....	14-17
<b>Тав. БИЧИГ ХЭРГИЙН ЧИГЛЭЛЭЭР:</b> .....	17
<b>Зургаа. ИРГЭНИЙ ЧИГЛЭЛЭЭР:</b> .....	18-19
<b>Долоо. ЭД ХӨРӨНГИЙН ЭРХИЙН БҮРТГЭЛИЙН ЧИГЛЭЛЭЭР</b> .....	20-22
<b>Найм. ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН БҮРТГЭЛИЙН чиглэлээр</b> .....	22-23
<b>Ес. АРХИВЫН ЧИГЛЭЛЭЭР:</b>	
9.1. Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн архивын чиглэлээр:.....	23
9.2. Хуулийн этгээдийн бүртгэлийн архивын чиглэлээр: .....	23-24
9.3. Иргэний бүртгэлийн архивын чиглэлээр: .....	24-25
<b>Арав. ХЯНАЛТЫН ЧИГЛЭЛЭЭР:</b> .....	25-27
<b>Арван нэг. САНХҮҮГИЙН ЧИГЛЭЛЭЭР:</b> .....	27-31

**ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН  
2021 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ  
БИЧМЭЛ ТАЙЛАН**

2021.12.03

Алтай хот

**Нэг: ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ**

**1.1 Бодлого зорилтыг хангах ажлын хүрээнд**

Говь-Алтай аймаг дахь Улсын бүртгэлийн хэлтэс нь “Иргэнд суурилсан төрийн бүртгэлийн үнэн ой санамжийг бий болгох, төр, иргэнийг холбосон бүртгэлийн нэгдсэн тогтолцоог бүрдүүлж, төрийн бүртгэлийн үйлчилгээгээр иргэний эрхийг хангах” эрхэм зорилгыг хангахын төлөө Засгийн газар, Хууль зүй дотоод хэргийн яам, Улсын бүртгэлийн ерөнхий газар, аймгийн Засаг дарга зэрэг дээд байгууллагуудаас ирүүлсэн захирамж хөтөлбөр, тушаал, шийдвэр, чиглэлийг хэрэгжүүлэн ажиллаж байна.

**1.2 Тогтоол, шийдвэр, хууль дүрэм, журмын хэрэгжилтийг хангах чиглэлээр:**

Үйл ажиллагаандаа Иргэний хууль, Улсын Их Хурал, Засгийн газрын тогтоол, Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Улсын бүртгэлийн ерөнхий хууль, Иргэний улсын бүртгэлийн тухай хууль, Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хууль, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль, холбогдох бусад хууль, тогтоомж, “Хөдөлмөрийн дотоод журам”, Улсын бүртгэлийн ерөнхий газраас болон орон нутгийн удирдлагаас өгсөн үүрэг даалгавар, удирдамж, чиглэл, тушаалыг мөрдлөг болгож иргэн, хуулийн этгээдэд эд хөрөнгийн улсын бүртгэл, иргэний улсын бүртгэл, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн үйлчилгээг орон нутагт эрхлэн зохион байгуулах үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэн 18 сум 88 багийн 58400 гаруй хүн амд бүртгэлийн үйлчилгээг хүргэн ажиллаж байна.

**1.4. Удирдлага, зохион байгуулалтын чиглэлээр:**

Говь-Алтай аймгийн улсын бүртгэлийн хэлтэс нь УБЕГГазрын даргын 2018 оны 07 дугаар сарын 20-ны өдрийн Б/07 тоот тушаалаар батлагдсан орон тооны дагуу Улсын бүртгэлийн хэлтсийн дарга 1, хяналтын улсын байцаагч 1, тасгийн дарга бөгөөд улсын ахлах бүртгэгч 2, эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн тасгийн улсын бүртгэгч 2, иргэний бүртгэлийн тасгийн улсын бүртгэгч 2, хуулийн этгээдийн улсын бүртгэгч 1, архивч 1, байгууллагын бичиг хэргийн эрхлэгч, нярав 1, ахлах нягтлан

бодогч 1, мэдээллийн технологийн ажилтан 1, гэрээт албан хаагч 2, 18 сумын 20 улсын бүртгэгч нийт 35 албан хаагчтайгаар үйл ажиллагаа явуулж байна.

## **Хоёр: ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛЭЭР/Зураг хавсралт-1/**

### **2.1. Хэлтсээсзохион байгуулсан ажил:**

- 2020 оны ХАСХОМ-ийг мэдүүлэх ёстой 26 албан тушаалтны хөрөнгө орлогын мэдүүлгийг 2021 оны 01 сарын 20-нд багтаан сүлжээнд бүрэн шивүүлж, баталгааны маягыг гаргуулан авч баталгаажуулан хадгалсан болно.Тайлант хугацаанд авилга, ашиг сонирхолын зөрчлийн асуудлаар иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдол, санал хүсэлт ирээгүй мөн хөрөнгө орлогоо мэдүүлэхээс татгалзсан, хугацаа хожимдуулсан албан тушаалтан байхгүй.

- Аймгийн ЗДТГ-аас 7 хоног бүр зохион байгуулдаг агентлагын дарга нарын шуурхай хуралд хэлтсийн дарга тогтмол оролцож, хуралд хэлэлцсэн цаг үеийн мэдээ мэдээллийг албан хаагчдад мэдээлж хэвшсэн.

- Албан хаагчдын ээлжийн амралтын хуваарийг хэлтсийн даргын 2021 01.15-ны өдрийн А/03 тушаалаар баталж мөрдүүлэн хуваарийн дагуу бүх албан хаагчид ээлжийн амралтаа эдэлсэн.

- 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн аудитаар “Зөрчилгүй” дүгнэлт авлаа.

- Мөн хэлтсийн албан хаагчдад сар бүр онлайнаар хурал зохион байгуулж цаг үеийн байдал, онцгой байдлын талаар болон тулгамдаж буй асуудал, Аймаг орон нутгийн удирдлага,УБЕГ-аас өгсөн үүрэг чиглэлийг тухай бүр танилцуулан ажиллаж байна.

- Тус хэлтэс нь 5 дугаар сард албан хаагчдын хүнсний хэрэгцээнд зориулж 0,5га газарт төмс, манжин, лууван гэх мэт хүнсний ногоог тус тус тариалж ургацаа хураан албан хаагчдад олголоо. Туслах аж ахуйн ямааны ноолуурын үнэ 640,000 төгрөгөөр “Эх үрсийн баяр”-ыг тохиолдуулан хэлтсийн албан хаагчдын 0-16 насны 64 хүүхдэд гарын бэлэг авч гардууллаа..

- Хэлтсийн байрны гадна, дотор тохижилтын ажлыг өөрсдийн нөөц бололцоонд тулгуурлан үе шаттайгаар хийлээ. 2021 оны тайлант хугацаанд хэлтсийн гадна хамгаалалтын камер 1-ийг байршууллаа. Мөн ногоон байгууламжийг сайжруулж гадна хайсийг шинэчлэн засаж 15ш улиас мод тарилаа.

- “Гэр бүлийн өдөр”-ийг тохиолдуулан хэлтсийн эцэг эхийн зөвлөлөөс хэлтсийн албан хаагчдын гэр бүлийн дунд “гар бөмбөг”-ийн нөхөрсөг тэмцээн,

хүүхдүүдийг оролцуулж гар зургийн уралдаан зэрэг арга хэмжээнүүдийг зохион явуулж түрүүлсэн баг, хүүхдүүдийг шагнаж урамшууллаа.

- Хэлтсийн албан хаагчдын шагналын судалгааг шинэчлэн гаргаж, Улсын бүртгэлийн ерөнхий газраас өгсөн чиглэлийн дагуу ажилдаа идэвхи зүтгэлтэй ажиллаж байгаа албан хаагчдыг хамт олны хурлаар хэлэлцэн шагналын материалыг хугацаанд нь УБЕГ-т хүргүүлж шийдвэрлүүлэн 6 албан хаагчийг шагнууллаа.

- Тайлант хугацаанд архивын стандартын хэрэгжилтийг хангах зорилгоор архивын нягтруулсан шүүгээ худалдан авах зардал 7.5 сая төгрөгийг Аймгийн Засаг даргаар шийдвэрлүүлж “Лүндээ-Очир” ХХК-иас архивын 6 ширхэг нягтаршуулсан шүүгээ захиалан авч архивт байршууллаа.

- Байгууллагын үйлчилгээний стандартыг мөрдөж хэвшүүлэхэд онцгойлон анхаарч Хэлтсийн даргын зөвлөлийн гишүүд нь албан хаагчдын харьцаа, хувцаслалт, ажлын цаг ашиглалтанд хуваарь гарган хяналт тавьж стандартыг хэвшүүлэн ажиллаж байна. Хяналтын ажлын явцыг Даргын зөвлөлийн хурлаар хэлэлцэн албан хаагчдад зөвлөмж хүргүүллээ.

- Монгол Улсын Засгийн газрын 2007 оны 190 дүгээр тогтоолын хэрэгжилтийг хангах зорилтын хүрээнд төрийн байгууллагууд 2021 онд хийсэн ажлаа иргэдэд сурталчилан таниулах, төрийн үйлчилгээг нэг дороос хүргэх, төрийн байгууллагын үйл ажиллагааны талаарх иргэдийн санал, хүсэлтийг хүлээн авах зорилгоор 2021 оны 10 дугаар сарын 22-ны өдөр Аймгийн засаг даргын тамгын газраас зохион байгуулсан “Нээлттэй хаалганы өдөр” арга хэмжээнд тус хэлтэс оролцож улсын бүртгэлийн үйл ажиллагааг иргэн, хуулийн этгээдэд сурталчлан ажиллав.

- Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр аймгийн Прокурорын газартай хамтран “Судалья, мэдье, сэргийлье” сэдэвт нөлөөллийн аяныг 2021.03.25-ны өдрөөс төрийн болон төрийн бус байгууллагуудын дунд өрнүүлэх ажлыг зохион байгууллаа. Аяны хүрээнд судлах хууль тогтоомжийг агуулсан хавтас, гарын авлага, DVD, туг, танилцуулах самбарыг тухайн байгууллагад аялуулж аяныг хүлээн авсан байгууллага дээрхи материалуудыг судалж дараагийн байгууллагад хүлээлгэн өгч ажиллалаа.

- Монгол Улсад бүртгэлийн байгууллага үүсэж хөгжсөний 81 жилийн ой, "Улсын бүртгэлийн ажилтны өдөр"-ийг тохиолдуулан улсын бүртгэлийн байгууллагын ажилтан, албан хаагчдын дунд зохион байгуулсан “Цэвэр монгол бичигтэн” уралдааны гутгаар байрт тус хэлтсийн Есөнбулаг сумын улсын бүртгэгч Д.Гүндэгмаа шалгарч талархал, мөнгөн шагналаар шагнуулсан. -Мөн улсын

бүртгэлийн байгууллагын 81 жилийн ойг угтан зохиогдсон 4 төрөлт /сагсан бөмбөг, гар бөмбөг, ширээний теннис, шатар/ спортын тэмцээнд тус хэлтсийн Есөнбулаг сумын улсын бүртгэгч Ч.Угтахбаяр, Нярав, дотоод ажилтан Э.Цэрэндулам нар баруун бүсийн багт тоглож Волейболын төрлөөр Алт, Сагсан бөмбөгийн төрлөөр хүрэл медаль авч амжилттай оролцлоо.

-Говь-Алтай аймаг нь 2021 онд "Үндэсний бичигтэн аймаг" болох томоохон зорилтыг дэвшүүлсэн . Тус ажлын хэрэгжилт үйл явц, үр дүнг үнэлэхээр Аймгийн засаг даргын ивээл дор, Соёл урлагийг дэмжих сангийн дэмжлэгтэйгээр төрийн албан хаагч, ард иргэдийн монгол бичгийн олимпиадыг 2021.11.22, 25-ны өдрүүдэд амжилттай зохион байгууллаа. "Монгол улсын Засгийн газраас баталсан "Монгол бичгийн үндэсний хөтөлбөр-III"-ыг хэрэгжүүлэх, эх хэлээ эрхэмлэн дээдэлж түгээн дэлгэрүүлэх, үндэсний бичгийн мэдлэг чадварыг ахиулах" зорилготой тус уралдаант шалгалтанд сум, хэлтсээсээ шалгаран 2-р шатанд оролцож, 3000 гаруй төрийн албан хаагч оролцсоноос тэргүүн байранд Төгрөг сумын улсын бүртгэгч С.Сарангэрэл, тусгай байранд Есөнбулаг сумын улсын бүртгэгч Д.Гүндэгмаа нар шалгарч шагнууллаа. Уг арга хэмжээнд төрийн байгууллагуудаас Улсын бүртгэлийн хэлтэс амжилттай оролцон шагналт 4-р байр эзлэв.

#### **Онлайн сум:**

- "Нийгмийн үйлчилгээний хүртээмжийг сайжруулах зорилгоор бүртгэлийн системийг боловсронгуй болгох" төслийн хүрээнд Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр онлайн сүлжээнд холбогдоогүй байсан Алтай сумыг 2021.06-р сард бүртгэлийн нэгдсэн онлайн сүлжээнд холбосноор тус аймгийн бүх сумд бүртгэлийн онлайн сүлжээнд холбогдлоо.

#### **Хамтын ажиллагаа:**

- Тус хэлтэс нь АймгийнЗасаг даргын Тамгын газар, Нийгмийн даатгалын хэлтэс,Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, Цагдаагийн газар, Тагнуулын хэлтэс, Татварын хэлтэс зэрэг байгууллагуудтай үйл ажиллагааны чиглэлээр тогтмол хамтарч ажиллаж байна.Тайлант жил эдгээр байгууллагуудаас нийт 352 хариутай бичиг ирсэнийг бүртгэж хариуг хугацаанд нь шийдвэрлэлээ.

- Говь-Алтай аймаг дахь ХААН, ХАС, ТӨРИЙН банкны захирал, удирдлагуудтай 2021.04.22-ны өдөр ажил хэргийн уулзалт ярилцлагыг зохион байгууллаа. Ковидын нөхцөл байдалтай холбогдуулан иргэдийг чирэгдүүлэхгүй, бөөгнөрөл үүсгэхгүй ажиллах талаар санал солилцож, хамтран ажиллаж байна.

- Монгол Улсын Ерөнхий сайдын ивээл дор 19 дэх жилдээ, Шинэ үндсэн хуулиа баталж, Бүгд Найрамдах улс тунхагласны түүхт 97 жилийн ойн баярын өдрийг тохиолдуулан аймгийн Засаг даргын тамгын газар, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газартай хамтран “Иргэний андгай өргөх ёслол”-ын арга хэмжээг зохион байгууллаа.

Монгол Улсын 16 нас хүрч, иргэний үнэмлэх авч байгаа өсвөр үе, залуучуудыг түүх соёлоо дээдэлсэн, эх оронч үзэлтэй, үүрэг хариуцлагаа ухамсарласан иргэн болгон төлөвшүүлэх зорилготой энэхүү арга хэмжээнд аймгийн 16 нас хүрч буй 86 сурагч оролцлоо.

#### **Шинэлэг ажил:**

- Хэлтсийн нийт албан хаагчдын сахилга хариуцлагыг дээшлүүлэх зорилгоор албан хаагч бүрт “Ажлын дэвтэр” хөтөлж үүрэг даалгаврын хэрэгжилтийг ханган ажиллаж хэвшлээ.

- Хамт олны ажиллах таатай орчныг бүрдүүлэх гэр бүлийн нөхөрсөг байдлыг хангаж эерэг хандлагыг нэмэгдүүлэх үүднээс долоо хоног бүрийн Мягмар гарагт аймгийн спорт зааланд гэр бүлээрээ спортоор хичээллэн чөлөөт цагийг өнгөрүүлж хэвшлээ.

#### **2.2. ОНЦ НӨХЦӨЛ БАЙДЛЫН ҮЕД АВЧХЭРЭГЖҮҮЛЖ БУЙ АРГА ХЭМЖЭЭ**

*/Зураг хавсралт-2/*

Улсын хэмжээнд өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт хэсэгчилсэн болон бүрэн шилжүүлсэн хугацаанд Улсын онцгой комисс, Улсын бүртгэлийн ерөнхий газар, Аймгийн онцгой комиссоос ирүүлж буй заавар, зөвлөмж, чиглэлийн дагуу тухай бүр нь арга хэмжээ авч ажиллаж байна. Үүнд:

- Аймгийн “Жаргалант-Алтай” өрхийн эмнэлэгтэй хамтран ажиллаж “Хамтын ажиллагааны төлөвлөгөө”-ний дагуу 2021 оны 04 сарын 08-ны өдөр хэлтсийн аймгийн төвийн 14 албан хаагчдыг эрүүл мэндийн үзлэгт оруулан Коронавируст халдварын эсрэг 1 тунгийн вакцинд, 2021 оны 04 сарын 29-ны өдөр вакцины 2 тунд тус тус хамруулав. Мөн сумдын улсын бүртгэгчдийг 2021 оны 04 сарын 29-ны өдрөөс 2021 оны 05 сарын 31-ны өдрийн хооронд вакцины 1,2 дугаар тунд бүрэн хамрууллаа.

- Вакцины 3 дугаар тунд тус хэлтсийн 20 албан хаагч хамрагдлаа. Вакцины 3 дугаар тунд хамрагдсан талаархи мэдээг заасан цаг хугацаанд УБЕГ-т хүргүүлэн ажиллалаа.

- Эрүүл мэндийн Яам, аймгийн Онцгой комиссоос гаргасан эрүүл мэндийн зөвлөгөө, халдвараас урьдчилан сэргийлэх сэрэмжлүүлэг, зөвлөмж бүхий

сурталчилгааны зурагт хуудсыг байгууллагын хаалга, үйлчилгээний танхим, үйлчилгээ үзүүлж буй цонхонд байршуулсан.

- ЭМЯ-аас гаргаж буй видео зөвлөмжүүдийг хэлтсийн үйлчилгээний зааланд дэлгэц байршуулан тогтмол явуулж иргэдэд хүргэж байна.

- Албан хаагчдад тус бүр гар халдваргүйжүүлэгч санитол , үйлчилгээ үзүүлэх цонх бүрт гар ариутгагч шингэнийг байрлуулж хэлтсийн нөөцөнд гар ариутгагч авч, дууссан албан хаагчид болон үйлчилгээний цонхны ариутгагч шингэнийг тогтмол цэнэглэж байна.

- Алсын зайнаас халуун хэмжих багажийг хэлтэст авч албан хаагчдыг өглөө ажилд ирэх болон ажлаас явах үед үйлчлүүлэгч иргэдийн биеийн халууныг нь тухай бүр үзэж тэмдэглэл хөтлөн ажиллаж байна.

- Хэлтсийн захиргаанаас улсын бүртгэлийн хэлтсийн үйлчилгээний заал, албан хаагчдын өрөө, архив, коридор, шат гээд байрны бүхий л хэсгүүдэд аймгийн мэргэжлийн байгууллага болох “ЗООНОЗ”-ын өвчин судлалын албаар сар бүр ариутгал халдваргүйжүүлэлтийг хийлгэн ажиллаж байна.

- УБЕГ-аас ирүүлсэн халдвар хамгаалалын хэрэгслийг албан хаагчдад жигд хуваарилан аюулгүй байдлыг ханган ажиллаж байна.

- Мөн албан хаагч бүрт 2 сар тутам дархлаа дэмжих үүднээс дархлааны витамин, аарц, чацаргана жимсийг олгож байна.

- Эрүүл мэндийн байгууллагын зөвлөмжийн дагуу тогтмол халуун шингэн юм уулгах зорилгоор албан хаагчдын өрөө бүрт суурин ус буцалгагч байрлуулсан.

- Мөн үйлчилгээний заал болон коридорт зай барьж зогсох санамжийг наасан.

- Хэлтсийн үйлчилгээний танхимд үйлчилгээ үзүүлж байгаа албан хаагчид болон үйлчлүүлэгч иргэдийн хорио цээрийн дэглэмийг ягштал баримтлуулах, үйл ажиллагаанд нь байнгын хяналтыг тавих зорилгоор 2 албан хаагчийг томилон үйлчилгээ авч байгаа иргэн бүрийн халууныг зайнаас халуун хэмжих багажаар үзэж, бүртгэл хөтлөн гарыг нь ариутгуулан маскгүй үйлчлүүлэгч иргэнийг маскаар ханган дотогш нэвтрүүлж байна.

- Хэлтсийн даргын баталсан хуваарийн дагуу албан хаагчдыг хариуцлагатай жижүүрт томилон ажиллуулж, цаг үеийн мэдээг холбогдох газар, хэлтэст хүргүүлэн ажиллаж байна.

- Цар тахлын үеийн байршлын мэдээлэл болох байгууллагын QR кодыг qr.119.mn хаягт бүртгүүлэн авч байгууллагын хаалганд наасан иргэдийг уншуулж орохыг сануулан ажиллаж байна.



- Тус хэлтэс нь 2021 оны 06 сарын 14-ны өдөр Улсын бүртгэлийн ерөнхий газраас КОЙКА-гийн төслөөр олгосон 8 төрлийн нийт 11.357 ширхэг хамгаалах ариутгалын хэрэгсэл хүлээн авч албан хаагчдын үйл ажиллагаанд ашиглаж байна.

### **2.3. АЛБАН ХААГЧДЫН АЖИЛЛАХ НӨХЦӨЛ БОЛОЛЦОО, НИЙГМИЙН БАТАЛГААГ ХАНГАХ ЧИГЛЭЛЭЭР: /Зураг хавсралт -3/**

- Улсын их хурлын гишүүн, Засгийн газрын гишүүн, Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатараар ахлуулсан ажлын хэсэг 2021 оны 05 дугаар сарын 20-ноос 2021 оны 05 дугаар сарын 21-нд Говь-Алтай аймагт ажиллаж хууль зүйн яамны харья байгууллагуудын үйл ажиллагаатай газар дээр нь танилцаж, зарим асуудлыг шийдвэрлэж зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллалаа. Ажлын хэсэгт УБЕГ-ын дарга Д.Дэлгэрсайхан ажилласан бөгөөд энэ үеэр Говь-Алтай аймаг дахь Улсын бүртгэлийн хэлтсийн байрны асуудлыг засвар хийх төсвийн хамт, албаны хэрэгцээнд шинэ автомашины асуудлыг тус тус газар дээр нь шийдвэрлэж, идэвх зүтгэлтэй ажилласан зарим алба хаагчдыг шагнаж урамшууллаа. Мөн сумдын бүртгэгчдийн албан хэрэгцээнд ашиглагдах иж бүрэн 20 компьютер, тоног төхөөрөмжийг олголоо. Улсын бүртгэлийн байгууллагад олон жил үр бүтээлтэй ажилласан 1 алба хаагчид өргөө цагаан гэр олголоо.

-Хэлтсийн даргын 2021 оны 01 дүгээр сарын 04-ны өдрийнБ/01тоот тушаалаар 3 албан хаагчийн цалингийн шатлал ахиулж 5 албан хаагчийн төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг ахиулан олголоо.

-Аймгийн Эрүүл мэндийн газартай хамтран 2021.02.20-ны өдөр хэлтсийн өндөр настан болон аймгийн төвийн албан хаагчдыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамрууллаа.

### **2.4. СОНГУУЛИЙН АРГА ХЭМЖЭЭНИЙ ҮЕЭР АВЧ ХЭРЭГЖҮҮЛСЭН АРГА ХЭМЖЭЭ: /Зураг хавсралт-4/**

Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хууль,түүнтэй холбоотой хууль тогтоомжийн дагуу бэлтгэл ажлыг хангаж амжилттай зохион байгуулан ажиллав. Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн ажлын хүрээнд:

- УБЕГ-ын даргын 2021.04.14-ны өдрийн Монгол улсын Ерөнхийлөгчийн ээлжит сонгуулиар хэсгийн хорооны дэргэд улсын бүртгэлийн байгууллагыг төлөөлөн ажиллах иргэний бүртгэлийн итгэмжлэгдсэн ажилтны орон тооны хязгаарыг баталсан А/239 тоот тушаалыг үндэслэн тус аймгийн сонгуулийн

хэсгийн хороодод ажиллах итгэмжлэгдсэн ажилтнуудын судалгааг гаргаж уг албан хаагчдыг Тагнуулын хэлтэст аюулгүй байдлын шалгалтанд хамруулав.

Аймгийн Тагнуулын хэлтсийн 2021.05.03-ны өдрийн 31/4/44 тоотыг үндэслэн Хэлтсийн даргын тушаалаар 88 итгэмжлэгдсэн ажилтныг томилж гэрээ байгуулан нууцын баталгаа гаргуулан авсан.

-Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулинд заасны дагуу 2021 оны 05 сарын 15-ний өдрөөс сонгогч шилжих журмын дагуу материалуудыг хүлээн авч 2021 оны 05 сарын 26-ны өдөр сонгогчийн шилжилтийг хааж жагсаалт, тайлан мэдээг УБЕГ-т хүргүүлж зөрчил, дутагдалгүй ажилласан.

-2021 оны ээлжит сонгуулийн санал авах байрын дэргэд ажиллах Улсын бүртгэлийн байгууллагын итгэмжлэгдсэн ажилтнуудад хэрэглэгдэх компьютер, тоног төхөөрөмжийг 2021 оны 05 сарын -ний өдрөөс 2021 оны 05 сарын -ны өдрүүдэд аймгийн Тагнуулын хэлтэс, Цагдаагийн газрын хамгаалалтанд Улсын бүртгэлийн ерөнхий газраас хүлээн авч аймгийн Тагнуулын хэлтсийн байранд байрлуулж ажилласан.

-2021 оны 05 сарын 13-ны өдөр Сонгогчийн нэрсийн жагсаалтыг хэвлэж, 2021 оны 05 сарын 14, 15 ний өдрүүдэд тус аймгийн 18 сумын сонгуулийн хэсгийн хороодод хүлээлгэн өгөх ажлын хэсгийг хэлтсийн тушаалаар томилон хугацаанд нь хүргүүлэн ажилласан.

-2021 оны 05сарын 29,30-ний өдрүүдэд итгэмжлэгдсэн ажилтнуудын програмын сургалтыг хийсэн. /дэлгэрэнгүйг “Сургалтын үйл ажиллагаа” сэдэвт байршуулав/

-2021.05.31-ны өдрөөс 2020.06.02-ны өдрүүдэд тус аймгийн 18 сумын сонгуулийн хэсгийн хороонд сонгогчийн нэрийн жагсаалт, компьютер хүлээлгэн өгөх ажлын хэсгийг хэлтсийн даргын тушаалаар томилж ажиллуулав.

-2021.06.09-ны өдөр Монгол Улсын Ерөнхийлөгчийн ээлжит сонгуулиар улсын бүртгэлийн байгууллагаас хэрэгжүүлэх чиг үүргийн дагуу ажиллаж ямар нэгэн алдаа зөрчил гаргаагүй.

### **Гурав: СУРГАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛЭЭР:**

Тус хэлтсийн албан хаагчдын хууль эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, эрүүл мэндийг хамгаалах зэрэг ажлуудын хүрээнд 2021 онд явагдах сургалт, сурталчилгааны төлөвлөгөөг баталж, төлөвлөгөөний дагуу ажлуудыг зохион явуулж байна.

#### **3.1. Ерөнхий газраас зохион байгуулсан сургалтууд:**

**УБЕГ-аас танхимаар зохион байгуулсан сургалтууд:**

- 2021 оны 05 дугаар сарын 29, 30-ны өдрүүдэд Улсын бүртгэлийн ерөнхий газрын Архивын газрын дарга С.Оюунгэрэлээр ахлуулсан сургалтын баг Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны ээлжит сонгуулийн санал авах байрын дэргэд ажиллах Улсын бүртгэлийн итгэмжлэгдсэн ажилтнуудад “Ирц бүртгэлийн программын сургалт”-ыг зохион байгуулж тус сургалтанд 88 итгэмжлэгдсэн ажилтан, тус хэлтсийн албан хаагчид хамрагдлаа.

**УБЕГ-аас онлайнаар зохион байгуулсан сургалтууд:**

- УБЕГ-аас өгсөн чиглэлийн дагуу ЗГХЭГ-аас зохион байгуулсан төрийн албан хаагчийг чадавхжуулахад чиглэсэн “Үр дүнд суурилсан төлөвлөлт, хяналт, шинжилгээ, үнэлгээ” сэдэвт цахим сургалтанд хэлтсийн төрийн захиргааны 29 албан хаагч хамрагдаж төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах аргачлалд суралцаж сертификат авлаа.

- 2021 оны 05 сарын 10-ны өдөр Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд УБЕГ-аас албан хаагчдад сонгуулийн тухай хууль тогтоомжийг таниулах, зөвлөмж чиглэл өгөх онлайн сургалтанд хэлтсийн дарга, Улсын ахлах бүртгэгч нар нар

- 2021 оны 05 сарын 11-ны өдөр Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны ээлжит сонгуулийн санал авах байранд ажиллах Улсын бүртгэлийн итгэмжлэгдсэн ажилтнуудад “Эрх зүйн цахим сургалт”-ыг зохион байгуулж тус сургалтанд 88 итгэмжлэгдсэн ажилтан, тус хэлтсийн шуурхай багийн бүрэлдэхүүн

- 2021 оны 06 дугаар сарын 07-нд Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэгч нарт зориулсан цахим сургалтанд эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэгч нар

- 2021 оны 06 дугаар сарын 17-нд Хуулийн этгээдийн Улсын бүртгэлийн үйл ажиллагааг зохицуулж байгаа захиргааны хэм хэмжээний актад оруулсан нэмэлт, өөрчлөлтийн талаарх сургалтанд Хуулийн этгээдийн улсын бүртгэгч З.Цэндсүрэн

- 2021 оны 06 дугаар сарын 17-23-ны өдрүүдэд зохион байгуулагдсан Иргэний улсын бүртгэлийн онлайн, оффлайн системийн талаархи нэгдсэн сургалтанд Хяналтын улсын байцаагч Д.Оюунчимэг, Ахлах, Нягтлан бодогч Б.Алтанбагана, Иргэний улсын бүртгэгч нар

- 2021 оны 06 дугаар сарын 18-нд "Төрийн албаны тухай болон архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн хэрэгжилт" арга зүйн сургалтанд Нярав, бичиг хэргийн ажилтан Э.Цэрэндулам, Архивч, Мэдээлэл технологийн ажилтан Э.Баатарсүрэн нар

- 2021 оны 06 дугаар сарын 25-нд Хүний эрхийн сургалтанд 22 албан хаагч

-2021 оны 08 дугаар сарын 20-нд Ховд аймагт болсон Орон нутаг дахь бүсийн сургалтанд хэлтсийн 31 албан хаагч

-2021 оны 08 дугаар сарын 20, 21 нд Мэдээлэл технологийн ажилтны нэгдсэн сургалтанд Мэдээлэл технологийн ажилтан Э.Баатарсүрэн

-2021 оны 09 дүгээр сарын.. өдөр болсон Хяналтын байцаагч нарын сургалтанд Хяналтын улсын байцаагч Д.Оюунчимэг, цахимаар зохион байгуулсан сургалтанд хэлтсийн дарга Г.Чүлтэмжамц нар

-2021 оны 09 дүгээр сарын ... өдөр болсон Удирдах ажилтны сургалтанд хэлтсийн дарга Г.Чүлтэмжамц тус тус хамрагдлаа.

-2021 оны 10 дугаар сарын 07-ны өдрөөс 10 дугаар сарын 28-ны өдрийг хүртэл Улсын бүртгэлийн ерөнхий газрын “2021-2024 оны үйл ажиллагааны стратеги төлөвлөгөө”-нд тусгагдсан сумаас эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн үйлчилгээг хүргэх ажлын хүрээнд сумдын улсын бүртгэгч нарт эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн чиглэлийн хууль эрх зүйн мэдлэг олгох анхан шатны сургалтанд Алтай, Тонхил, Баян-Уул, Чандмань, Халиун, Тайшир, Эрдэнэ сумдын эрх зүйч мэргэжилтэй 7 албан хаагч нар тус тус хамрагдаж шалгалтаа амжилттай өглөө.

-2021 оны 10 дугаар сарын 08-нд Улсын бүртгэлийн байгууллагын хүний нөөцийн мэдээллийн систем ашиглалтад орж, албан хаагчдын мэдээллийг системд үнэн зөв оруулах үүднээс албан хаагчид өөрт нь 1 удаа мэдээллээ засаж оруулах эрхийг 2 хоногийн хугацаатай нээсэн даруйд бүх албан хаагч мэдээллээ шинэчлэв.

-2021 оны 10 дугаар сарын 15-нд Авлигатай тэмцэх газраас зохион байгуулсан 2021 онд нийтийн албанд шинээр томилогдсон албан хаагчдад зориулсан цахим сургалтанд шинээр томилогдсон 4 албан хаагч

-2021 оны 10 дугаар сарын 15-ны өдөр аймгийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зөвлөлтэй хамтран “Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр зохион байгуулсан онлайн сургалтанд хэлтсийн албан 19 хаагч

-2021 оны 10 дугаар сарын 21-нд УБЕГ-ын Тамгын газрын даргын баталсан "Галын аюулгүй байдлыг хангах" сэдвээр зохион байгуулсан цахим сургалтанд хэлтсийн архивч, Мэдээлэл технологийн ажилтан нар

- 2021 оны 10 дугаар сарын 26-нд УБЕГ-ын Эрх зүйн хэлтсээс зохион байгуулсан “тероризм,хүн худалдаалах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх” чиглэлээр зохион байгуулсан онлайн сургалтанд хэлтсийн 16 албан хаагч

- 2021 оны 10-р сарын 27-нд Төрийн албан зөвлөлөөс зохион байгуулсан "Хүний нөөцийн нэгдсэн систем"-ийн онлайн сургалтанд бичиг хэргийн ажилтан, нягтлан бодогч нар

- 2021 оны 11 дүгээр сарын 29-нд "Архив, албан хэрэг хөтлөлийн ойлголт, анхаарах асуудал" сэдэвт сургалтанд Архивч, Мэдээлэл технологийн ажилтан нар тус тус хамрагдав.

### **3.2. Аймаг орон нутгаас зохион байгуулсан сургалтууд:**

- 2021 оны 03 дугаар сарын 23-ны өдөр аймгийн ЭМГ, Онцгой байдлын газраас зохион байгуулсан "Ковид-19 цар тахал өвнөөс урьчилан сэргийлье" сэдэвт сургалтанд хэлтсийн 11 албан хаагч онлайнгаар хамрагдаж зохих мэдээллийг авсан.Коронавируст цар тахал өвчний дэгдэлт нэмэгдсэнтэй холбоотойгоор сургалтын арга хэмжээг хорьж хөл хорио тогтоосон тул сургалтууд явагдаагүй.

### **3.4. Хэлтсээс зохион байгуулсан сургалтууд:**

- 2021 оны 01 дүгээр сарын 22-ны өдөр Улсын бүртгэлийн хэлтсээс "Гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулахад анхаарах асуудлаар" онлайн сургалт зохион байгуулж төрийн захиргааны 25 албан хаагч хамрагдсан.

-2021 оны 03 дугаар сар 21-ны өдөр Есөнбулаг сумын 10 багийн засаг дарга, нийгмийн ажилтнуудад цахим үнэмлэх болон бүртгэлийн хугацаа, 16 нас хүрээд анх удаа авч байгаа болон 25,45 насны сунгалт, эд хөрөнгө өмчлөх эрхийн талаар сургалтыг зохион байгуулсан.

-АймгийнТагнуулын хэлтэстэй хамтарч2021.04.02-ний өдөр тагнуулын ажилтан, ахмад Д.Пүрэвням, З.Бат-Орших нар Төрийн нууцын тухай хууль, сүлжээний аюулгүй байдал, цахим гэмт хэрэг түүний хор уршиг зэрэг сэдвээр 1 цагийн онлайн сургалт хийлээ. Тус сургалтанд хэлтсийн 15 албан хаагч хамрагдав.

-2021 оны 05 дугаар сарын 11-ны өдөр МонголУлсын Ерөнхийлөгчийн ээлжит сонгуулийн тухай хууль, түүнтэй холбоотой хууль тогтоомжийг нэг мөр ойлгон хэрэгжүүлэх, санал авах өдөр сонгогчийн бүртгэлийг нягтлан шалгахтай холбоотой анхаарах асуудлуудын талаар болон эрх зүйн мэдлэг олгох цахим сургалтыг зохион байгуулж 88 итгэмжлэгдсэн ажилтан, шуурхай багийн албан хаагчид бүрэн хамрагдлаа.

"2021 оны 05 сарын 16-ны өдөр Монгол Улсын Ерөнхийлөгчийн ээлжит сонгуулийн санал авах байранд ажиллах Улсын бүртгэлийн итгэмжлэгдсэн ажилтнуудад Төрийн нууцын тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Зөрчлийн тухай хууль, бусад хууль тогтоомжоор Аймгийн тагнуулын хэлтсийн ажилтан З.Бат-Орших,

Цагдаагийн газрын хэв журам хамгаалах тасгийн дарга Л.Гантулга нартай хамтран сургалт зохион байгуулж тус сургалтанд 88 итгэмжлэгдсэн ажилтан, тус хэлтсийн албан хаагчид хамрагдав.

**Дөрөв: ХЭЛТСИЙН МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД, НЭЭЛТТЭЙ БАЙДЛЫГ  
ХАНГАХ, МЭДЭЭЛЭЛ ТЕХНОЛОГИЙН ЧИГЛЭЛЭЭР:** /Зураг хавсралт-5/

Цахим хаяг: <https://govi-altai.burtgel.gov.mn/>

Фэйсбүүк хаяг: /Говь-Алтай аймаг дахь Улсын бүртгэлийн хэлтэс/

Фэйсбүүк хаяг: /байгууллагын албан хаагчид зөвхөн орох, дотоод албан бичиг, мэдээ мэдээлэл солилцох/: [/GAA-n UBHeltes/](#)

**Цахим хуудас болон мэдээллийн самбарт байршуулсан мэдээлэл.**

➤ Ерөнхий газраас нэгдсэн цахим хуудсыг ашиглахаар болсны дагуу доторх мэдээ мэдээллийг тухай бүр нь шинэчилж ашиглаж байна.

➤ “НҮҮР ХУУДАС” буланд тус аймгийн түүхэн замнал, үүсэл гарал, аймгийн үзэсгэлэнт газар, фото альбом, газрын зураг, топ мэдээ, цаг үеийн мэдээлэл, видео мэдээ, бусад шаардлагатай баннераар дамжуулан мэдээ мэдээллийг байрлуулан тухай бүр нь мэдээллийг тогтмол шинэчилэн ажиллаж байна.

➤ “ТАНИЛЦУУЛГА” буланд тус хэлтсийн тухай товч танилцуулга, бүтэц зохион байгуулалт, албан хаагчдын и-мэйл хаяг, холбоо барих утас зэргийг байрлуулсан. Шинэчлэлийг тухай бүр нь хийж хэвшсэн.

➤ “ИЛ ТОД БАЙДАЛ” буланд Нийтэд хамаарал бүхий төсөв санхүүгийн тухай мэдээ мэдээлэл, шилэн данс, хурал сургалт, семинарь, хэлэлцүүлгийн зар, байгууллагын жил улирлын тайлан, төсөв санхүүгийн ил тод байдлын талаар байрлуулан тогтмол шинэчлэлтийг хийж ажиллаж байна. Мөн байгууллагын ил тод байдлын самбарт давхар байрлуулан иргэдэд төсөв санхүүгийн талаар байнга ил тод мэдээллэж байна.

➤ “ХЭРЭГЧЛЭГЧ ТАНД” буланд иргэдийн дунд эргэлзээтэй байдаг байнга асуудаг “Түгээмэл асуулт, хариулт”-уудыг байрлуулан УБЕГ-ын түгээмэл асуулт хариулт цэсийг давхар холбож өгсөн. Мөн ажлын байрны зар, Өргөдөл гомдлын шийдвэрлэлт, Сар бүрийн тоон мэдээлэл зэргийг тухай бүр нь байрлуулан тогтмол шинэчлэн ажиллаж байна.

➤ “ХОЛБОО БАРИХ” буланд Үйлчилгээ, захидал харилцааны асуудал хариуцсан албан хаагчийн эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр албан тушаал, ажиллах журам, харилцах утас болон хэлтсийн даргын “Иргэдийг хүлээн авч уулзах цагийн

хуваарь”-ийг /хэлтсийн даргын өрөөний үүдэнд байрлуулсан/ байрлуулан тогтмол шинэчлэн ажиллаж байна.

➤ “БАННЕР” цэстE-mongolia, Шилэн данс, Улсын бүртгэлтэй холбоотой мэдээ мэдээллийн ведио сан, Монгол бичгийн хичээл, Burtgel.mn, Open data, Хуулийн этгээдийн нэр баталгаажуулах, Хуулийн этгээд бүртгүүлэхэд шаардлагатай барим бичиг, Авлигатай тэмцэх газар, Хэлтсийн фэйсбүүк хаяг, журам дүрмийн төсөл зэрэг баннерийг байрлуулан иргэдэд сурталчилан ажиллаж байна.

➤ Төрийн албан хаагчийн эрхэмлэх 9 зүйл, ёс зүйн дүрэм зэргийг байгууллагын үйлчилгээний зааланд байрлуулж, Албан хаагч нарт мөрдүүлж, хэвшүүлж байна.

#### **Сурталчилгааны чиглэлээр:**

➤ Байгууллагаас үзүүлж байгаа үйлчилгээний талаарх мэдээ мэдээллийг хэлтсийн цахим хуудас болон фэйсбүүк хаягаар дамжуулан иргэдэд тухай бүр нь тогтмол хүргэж хэвшсэн бөгөөд аймгийн Алтай ТВ болон Говийн мэдээ сонингийн газартай хамтран ажиллаж иргэдэд аль болох хурдан шуурхай хүргэх арга хэмжээг зохион байгуулан ажиллаж байна. Тайлант онд ярилцлага 2 удаа, live сурвалжлага 3 удаа, сонинд мэдээг 4 удаа өгсөн байна. Хэлтсээс иргэдэд зориулж бүртгэлийн байгууллагын цахим сан, E-MONGOLIA цахим сайтаас мэдээлэл лавлагаа авахад шаардагдах өндөр хурдны интернэт, принтер байрлуулсан өрөөг тохижуулан заавар зөвлөгөө өгч брошур байршуулан ажиллаж байна.

➤ Мөн үйлчилгээний зааланд иргэдэд мэдээлэл хүргэх үүднээс байгууллагын LCD зурагтыг байршуулан мэдээллийг байнга шинэчилж, цар тахлын цаг үеийн мэдээ мэдээлэл холбогдох шторк видеог байнга явуулж иргэдэд анхааруулга сэрэмжлүүлэг болгон ажиллаж байна.

➤ Цар тахлын үед иргэдийг улсын бүртгэлийн байгууллагыг зорихгүйгээр цахимаар үйлчилгээ авах талаар заавар зөвлөгөө мэдээ мэдээллийг байгууллагын цахим хаяг, фэйсбүүк хаягаар дамжуулан хүргэх мөн утсаар зөвлөгөө мэдээлэл өгч ажиллаж байна.

➤ Тасаг нэгжийн болон бүртгэгч бүрийн өмнө танилцуулга, ажлын чиг үүрэг, албан тушаалыг харуулсан танилцуулгыг бэлдэж иргэдийн ямар үйлчилгээг хэнээс яаж авах талаар мэдээллийг авах боломжийг бүрдүүлсэн мөн цар тахлын үед иргэдийг шуурхай үйлчилгээ авах боломжийг ханган 2 угтах ажилтан гаргаж ажиллаж байна.



➤ Бүртгэлийн үйлчилгээний үнэ тариф, бүрдүүлэх баримт бичиг, мөнгө тушаах дансны мэдээлэл, үйлчилгээ үзүүлж буй хаяг байршлыг агуулсан самбарыг байгууллагын коридорт байршуулсан.

#### **Үйл ажиллагааны аюулгүй байдлыг хангах чиглэлээр:**

Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2021 оны 01 дүгээр сарын 14-ний өдрийн “Журам батлах тухай” А/02 тоот тушаалаар баталсан “Улсын бүртгэлийн цахим мэдээллийн нэгдсэн санд мэдээлэл хүлээн авах, хадгалах, түүний аюулгүй байдлыг хангах журам”-ийн дагуу үйл ажиллагааны аюулгүй байдлыг ханган ажиллаж байна.

Мөн аюулгүй байдлыг хангах үүднээс дараах арга хэмжээг авч ажиллаж байна.

➤ Албан хаагчдын компьютерийн плаш оролтуудыг бүрэн хаасан. Мөн аюулгүй байдлын санамжийг компьютер болгон дээр наасан.

➤ Албан хаагчдын ашиглаж байгаа компьютер болон програмуудын нууц үгийг 14 хоногоос 1 сар дотор заавал солиулж, солиулсан талаар бүртгэл хөтлөн гарын үсэг зуруулан ажиллаж байна.

➤ Байгууллагын архив, сүлжээ сервер болон үйл ажиллагааны аюулгүй байдлыг хангах цаг ашиглалтыг сайжруулах зорилгоор үйлчилгээний заал, коридор, архивын гадна дотор хаалга, сургалтын заал зэрэгт камер байрлуулан ажиллаж байна.

➤ Үйл ажиллагаанд ашиглаж байгаа компьютер процессорыг гадны этгээд дотор эд ангийг тонохоос сэргийлж УБЕГ гэсэн лацаар лацдаж бүртгэл хөтөлсөн.

➤ Хэлтсийн үйлчилгээнд ашиглагдаж байгаа интернэтэд холбогддог нийт 9 компьютерийг BITDEFENDER вирусны жилийн лицензтэй програмаар хамгаалсан.

➤ Тог цахилгааны эрсдэлээс сэргийлэн УБЕГ-аас хэлтэст ирүүлсэн 11ширхэг тог тогтворжуулагчийг тогны асуудалтай сумд болон хэлтсийн сервер, үйлчилгээний заал, нэг цонхонд байрлуулан ажилласан.

#### **Мэдээлэл технологийн үндсэн үйл ажиллагаа, ажил үүргийн хуваарьт заагдсан ажил үйлчилгээний чиглэлээр:**

Тус хэлтсийн тоног төхөөрөмжийг УБЕГ-аас бүрэн шинэчлэсэн тул засвар үйлчилгээ хийгдээгүй. Сумдад ирүүлсэн 22 ширхэг шинэ компьютерт холбогдох программ хангамжуудыг суулгаж, плаш оролтуудыг хаалаа.



Хэлтсийн серверийн роутер тус аймгийн Мэдээлэл холбоо сүлжээний газарт байрладаг байсныг хүсэлт гаргаж Хэлтсийн байранд шилэн кабел татуулан серверийн өрөөнд зөөвөрлөх ажлыг тайлант оны 03 сард хийж гүйцэтгэсэн. Одоогоор сүлжээ серверийн хэвийн жигд ажиллаж байгаа болно.

### **Тав. БИЧИГ ХЭРГИЙН ЧИГЛЭЛЭЭР:**

Тайлант хугацаанд тус хэлтсээс нийт 968 албан тоотыг явуулснаас хууль хяналтын байгууллагад 351, Аймгийн ЗДТГ, ИТХ-д 28, УБЕГ-т 405, бусад албан байгууллагад 184 албан бичгийг хүргүүлсэн байна. Мөн 311 бичиг ирсэн. Үүнд:Хууль хяналтын байгууллагаас 18, Аймгийн ЗДТГ, ИТХ-аас 60, УБЕГ-аас 178, бусад байгууллагаас 55 бичиг ирсэн байна.

Тайлант хугацаанд хэлтэст нийт 433 хариутай бичиг ирснээс Хууль, хяналтын байгууллагаас 328, аймгийн ЗДТГ, ИТХ-аас 38, УБЕГ-аас 43, бусад байгууллагаас 24 албан бичиг ирсэнийг холбогдох албан хаагчид даргын цохолтоор хүргүүлж 100 хувь шийдвэрлэсэн байна. Хэлтэст нийт 44 өргөдөл ирсэнээс 36 өргөдлийг хуулийн хугацаанд нь бүрэн шийдвэрлэж 8 өргөдөл шийдвэрлэх шатандаа явж байгаа талаар батлагдсан маягт, хүснэгтийн дагуу нэгтгэж тайлан мэдээг УБЕГ болон аймгийн ЗДТГ-т тус тус хүргүүлэн ажиллалаа.

Үүнд: Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн үндсэн үйл ажиллагаатай холбоотой асуудлаар 2, Бүртгэлийн хяналтын үндсэн үйл ажиллагаатай холбоотой асуудлаар 32, Хуулийн этгээдийн талаар 1, санхүүгийн үйл ажиллагаатай холбоотой 9 өргөдөл тус тус ирсэнийг холбогдох албан хаагчдад нь даргын цохолтоор хүргүүлж шийдвэрлүүлэн ажилласан. Тайлант хугацаанд хэлтсээс явуулж байгаа баримт бичгийг стандартын дагуу хөтлөн явуулж, хэлтэст ирүүлсэн өргөдөл, гомдол, хариутай бичиг, албан тоотыг бүртгэлийн дэвтэрт бүртгэж [loffice.govi-altai.gov.mn](mailto:loffice.govi-altai.gov.mn) мөн Able буюу Албан хэрэг хөтлөлтийн программ ашиглан, хариутай, ирсэн, явсан бичиг хяналтын карт хэвлэж, холбогдох албан хаагчдад нь танилцуулж хариуг хугацаанд нь хүргүүлэн ажиллалаа.

2021 онд тус хэлтсийн сар, улирал, өдөр тутам гаргах тайлан, мэдээг хугацаанд нь гаргаж харъяалагдах байгууллагад хүргүүлж ажилласан. Улсын бүртгэлийн ерөнхий газрын [hariutslagatai\\_jijuur@burtgel.gov.mn](mailto:hariutslagatai_jijuur@burtgel.gov.mn) хаягт өдөр бүр 15:00 цагт ажлын тоон мэдээ болон албан хаагчдын ирц, Ковидын нөхцөл байдлын талаархи мэдээг хүргүүлэн ажиллаж байна.Сумдын бүртгэгч нарын сарын тайлан, мэдээ болон бүртгэлийн ХААТР маягыг тусгай дэвтэр хөтлөн хариуцсан албан хаагчдад хүлээлгэн өгч хэвшлээ.

## **Зургаа. ИРГЭНИЙ УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЧИГЛЭЛЭЭР:**

12-р сарын 01-ны байдлаар шинэ төрсөн-1189, үрчлэлт-18, гэрлэлт-313, гэрлэлт цуцлалт-15, эцэг тогтоолт-38, овог нэр өөрчлөлт-43, нас баралт-295, иргэний шилжилт хөдөлгөөний бүртгэлээр бусад аймаг хотоос шилжин ирсэн-276, аймаг доторхи шилжилт хөдөлгөөний бүртгэлээр-825 иргэний бүртгэлийг тус тус бүртгэж хянан баталгаажуулсан. Мөн иргэний шинэчилсэн бүртгэлд шинээр хамрагдсан-814, иргэний үнэмлэхний хугацаа дууссан-1336, дахин олгосон иргэний үнэмлэх-485 иргэнд иргэний үнэмлэхнийг шинээр болон дахин олгосон, гадаад паспорт авах-134 иргэний хүсэлтийг хүлээн авч гадаад паспортыг хэвлүүлэн хүлээн авч иргэдэд олгосон.

Нэмэлт өөрчлөлтийн бүртгэлээр-10 бүртгэл, хяналтын улсын байцаагчийн 37 дүгнэлт, архивын нотлох баримтаар-116 иргэний мэдээллийг мэдээллийн санд засуулахаар ИБГ-т албан тоотоор хүргүүлсэн. Нэрийн санд хаяггүй-5 иргэдийн бүртгэл байхгүй, шүүхээр болон хяналтын улсын байцаагчийн дүгнэлтээр-8 иргэнд регистрийн дугаар өөрчилсөн иргэний бүртгэлтэй холбоотой өргөдөл гомдол ирээгүй болно.

Хууль хяналтын байгууллагаас иргэдийн лавлагаа, нотлох баримт гаргуулах 55 албан бичиг хүлээн авч хууль журмын дагуу 1387 лавлагаа, нотлох баримт 334 гаргаж шийдвэрлэсэн.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны ээлжит сонгуулиар улсын бүртгэлийн байгууллагын хэрэгжүүлж ажиллах үйл ажиллагааны төлөвлөгөө болон МУЕС-ийн тухай хуулийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд цахим мэдээллийн сангаас тухайн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжид байнга оршин суугаа газрын бүртгэлтэй сонгогчийн тоог аймгийн Иргэдийн төлөөлөхдийн хурлын тэргүүлэгчдэд хүргүүлж, тус аймгийн 18 сумын ИТХТ-дийн сонгуулийн хэсэг байгуулж, хэсгийн нутаг дэвсгэр, төвийг зарласан тогтоолтыг хүлээн авч нэгтгэж, мэдээллийн санд шивэн баталгаажуулж, эх хувийг УБЕГ-ын ИБГ-т тогтоолын нэгтгэл, илтгэх хуудсын хамт, Хяналт шалгалтын газарт хуулбар хувийг тус тус хүргүүлсэн.

Сонгуулийн эрх бүхий иргэнд хэсэг оноох ажлыг сонгогчдын нэрийн жагсаалтанд бүртгэгдсэн тус аймгийн 88 хэсгийн 37.874 иргэнд хуулийн хугацаанд хэсэг оноох хянан баталгаажуулах ажлыг хийж гүйцэтгэсэн. Сонгуулийн санал авах байранд Улсын бүртгэлийн байгууллагыг төлөөлөн ажиллах итгэмжлэгдсэн ажилтнуудад зориулсан сургалтыг онлайнаар-1, УБЕГ-ын сургалтын багтай хамтран танхимаар-1 удаа тус тус зохион байгуулсан. Сонгуулийн өдөр техник

тоног төхөөрөмжтэй холбоотой болон бусад асуудлаар ямар нэгэн зөрчил, дутагдал гараагүй. Сумдын улсын бүртгэгч нарыг мэргэжил арга зүйгээр байнга ханган, шинээр томилогдон ажиллах улсын бүртгэгч нарт Улсын бүртгэлийн ерөнхий хууль, Иргэний бүртгэлийн хууль, гэр бүлийн тухай хууль, эдгээртэй уялдан гарсан хууль тогтоом, журмыг бүрэн судлах, аймгийн төвд 3-5 хоног дадлага хийлгэж заавар зөвлөгөө өгч ажиллаж байна.

Иргэд, байгууллагад цар тахлын үед иргэний бүртгэлтэй холбоотой лавлагаа мэдээллийг E-Mongolia системийг ашиглаж танхимаар үйлчилгээ авахгүй байхыг байнга зөвлөж ажиллаж байна. УБЕГ-ын даргын баталсан удирдамжийн дагуу УБЕГ-ын Хяналтын газраас төлөвлөгөөт шалгалтыг 2021 оны 10 дугаар сарын 25 - 30 хооронд 2021 оны 1-р сараас 10 сар хүртэлх хугацаанд бүртгэсэн иргэний бүртгэлийн үйл ажиллагааг нотлох баримтын бүрдүүлбэр, холбогдох хууль, журамд нийцсэн эсэхийг 18 сумын бүртгэлийг татан авч шалгасан.

Архивын чиглэлээр иргэдэд болон албан хэрэгцээнд зориулж нийт-3380 лавлагаа гаргаснаас иргэдэд-1791, хууль хяналтын байгууллагын албан тоотоор-1133, албан хэрэгцээнд-456 лавлагааг тус тус гаргаж, иргэний баримтын архивын хувийн хэргийн санд-76 иргэний хувийн хэргийг шинээр үүсгэж, ИУБ-11-ИУБ-18 маягт 490 төрөлжүүлэн байршуулж, бусад аймаг хотруу шилжин явсан-234 хувийн хэргийг ялган шилжүүлж, аймаг хотоос шилжин ирсэн-165 иргэний хувийг хэргийг галиглан байршуулсан. Сарын мэдээг нэгтгэн гаргаж холбогдох газруудад хугацаанд нь хүргүүлэн ажилласан.

УБЕГ-ын болон Хэлтсийн 2021 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгасаны дагуу тус аймгийн 18 сум, 2 тосгоны нутаг дэвсгэрийн хэмжээнд байрлаж байгаа гудамж, зам талбай, үл хөдлөх хөрөнгийг хаягжуулах тухай Монгол Улсын хаягжуулалтын тухай хууль, журмыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд судалгаа хийхэд 2016 онд бүх сум ИТХТ-ийн тогтоол гаргаж, аймгийн Газрын харилцаа, Барилга хот байгуулалтын газар болон Геокад ХХК-тай хамтран сумын төвийн гудамж, зам талбайг хаягжуулах кадастрын зургийг хийлгэсэн байна. Чандмань сум, сумын төвөө багтай болгож хаягжуулалтын хуулийн дагуу гудамж хашаа байшингийн хаягийг нааж, тухайн багт оршин суух иргэдийн хаягийг мэдээллийн санд оруулж иргэдийг шинэ хаягаар бүрэн хаягжуулсан. Мөн Дэлгэр сумын Гуулин тосгоны хаягжилт бүрэн хийгдсэн байна. Орон нутгийн хөгжлийн сангаас 11 сум төвийн гудамж хашаа, байшингийн хаягаа нааж хаягжуулсан.

## **Долоо.ЭД ХӨРӨНГИЙН ЭРХИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЧИГЛЭЛЭЭР:**

2021 оны 12 сарын 01-ны өдрийн байдлаар иргэн, хуулийн этгээдийн Эд хөрөнгө өмчлөх эрх болон түүнтэй холбоотой бусад эрхийн 4420 мэдүүлэг хүлээн авснаас нотлох баримтын шаардлага хангаагүй 76 мэдүүлгийг буцааж 4344 мэдүүлэг хүсэлтийг хуулийн хугацаанд 100% шийдвэрлэв. Үүнд:Газраас бусад үл хөдлөх хөрөнгө анх удаа өмчлөх эрхийн 227, төрөөс хувьчилсан газар өмчлөх эрхийн 128,төрөөс худалдаж авсан газрын өмчлөх эрхийн 1, худалдах худалдан авах гэрээгээр өмчлөгч өөрчлөгдөх 335, бэлэглэх гэрээгээр өмчлөгч өөрчлөгдөх 128, өв залгамжлалаар өмчлөгч өөрчлөгдөх 55, хамтран өмчлөгч өөрчлөгдөх 27, өмчлөгчийн хүсэлтээр болон гэрээгээр шинэ бүртгэл үүсэх 84, барьцаат зээлийн гэрээний 1926, барьцаат зээлийн гэрээ дуусгавар болгох 1135, лавлагаа хуулбар олгох 56, бүртгэлд өөрчлөлт оруулах 151,гээгдүүлсэн болон гэмтээсэн гэрчилгээ дахин олгох 12, бүртгэл хаах 3 бүртгэлийг тус тус хийж гүйцэтгэлээ.

Бүртгэлийн үйлчилгээний хураамжаар иргэн, хуулийн этгээдээс 178.109.352 төгрөг, улсын тэмдэгтийн хураамжаар 2.261.152 төгрөг, үл хөдлөх хөрөнгө худалдан борлуулсны татварын орлого 189.670.831 төгрөг тус бүрийг улсын болон орон нутгийн төсөвт тушаалгаж ажиллалаа.

Газар эзэмших ашиглах эрхийн дундын мэдээллийн санд 1072 хүсэлтийг хүлээн авч улсын бүртгэлийн Э болон А дугаарыг олголоо.

ЭХЭУБГазарт газар эзэмших ашиглах эрхийн Э дугаар болон ePRS програм дахь Г дугаарын 19 давхардлын судалгааг 1,4,6-р саруудад тус тус тогтсон хугацаанд ЭХЭУБГазарт хүргүүлсэн.

Цахим мэдээллийн санд оруулсан 138 засвар өөрчлөлт оруулсан тайланг 2021оны 1,3,4,11-р саруудад тус тус тогтсон хугацаанд ЭХЭУБГазарт хүргүүлсэн.

Бүртгэлийн тоон мэдээг сараар, үнэт цаасны тайланг сараар, орлогын тайланг сараар, улсын тэмдэгтийн хураамжийн тайланг улирлаар тухай бүр хугацаанд нь нэгтгэн тайлагнасан. 2021оны 1-р сард архивын хувийн хэргийн ангилан ялгасан хуудасны тооллогыг хийж тусгаарласан хуудасны судалгааг гаргаж ЭХЭУБГазарт хүргүүлсэн.

2021оны 1-р сард Аймгийн Засаг даргын тамгын газарт иргэн, хуулийн этгээдийн үл хөдлөх хөрөнгө өмчлөлийн судалгааг нас хүйс төрлөөр гаргаж хүргүүлсэн.

2021оны 3-р сард шинээр баригдсан ба жагсаалтаар салж бүртгэгдсэн орон сууцны судалгааг дэлгэрэнгүй байдлаар гаргаж ЭХЭУБГазарт хүргүүлсэн.

Үл хөдлөх эд хөрөнгө өмчлөх эрхийн гэрчилгээний 719ш, газар өмчлөх эрхийн гэрчилгээний 480ш, лавлагааны 56ш үнэт цаасыг ашигласан ба иргэд хуулийн этгээдэд олгосон байна.

Аймгийн хэмжээнд нийт 3200 гаруй иргэн хуулийн этгээдэд биечлэн болон утсаар, онлайн хэлбэрээр бүртгэлийн хууль тогтоомж, ажил үйлчилгээний талаар зөвлөгөө мэдээлэл өглөө. Аймгийн Газрын харилцаа барилга хот байгуулалтын газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, тойргийн нотариатууд, Татварын хэлтэс, Сумдын тамгын газрын дарга нартай тогтмол мэдээлэл солилцож хамтран ажиллалаа.

2021оны 4-р сард аймгийн төвд үйл ажиллагаа явуулж байгаа банкны удирдлагуудтай уулзалт хийж, тулгамдаж буй асуудлуудаар санал солилцож, цаг үеийн нөхцөл байдалтай уялдуулж ажлын байран дээр иргэдийн бөөгнөрөл үүсгэхгүй байх, халдвар хамгааллын дэглэм баримтлах талаар хамтран ажиллахаар шийдвэрлэж барьцаат зээлийн гэрээг бүртгүүлэхэд иргэдийн мэдүүлэг нотлох баримтыг банкны ажилтнуудаар дамжуулж хүлээн авах ажлыг хэрэгжүүллээ.

2021оны 10-р сард аймгийн Нотариатч нар, Газрын харилцаа барилга хот байгуулалтын газрын хэлтсийн дарга, 2 мэргэжилтэн, Хаан, Хас, Төрийн банкны ахлах мэргэжилтэнгүүд, ББСБ-ийн эдийн засагч нартай уулзалт хийж гэрээ хэлцэл, газрын мэдээллийн цахим систем, барьцаат зээлийн гэрээ, барьцаалбартай холбоотой маргаантай асуудал, тулгамдаж буй асуудлаар зөвлөлдөж мэдээлэл солилцлоо.

2021оны 11-р сард Аймгийн хэмжээнд зохиогдсон “Нээлттэй хаалганы өдөр” арга хэмжээнд 2 бүртгэгч оролцож иргэд хуулийн этгээдэд зөвлөгөө мэдээлэл өгч ажилласан.

Цахим сан дахь 285 бүртгэлийн нотлох баримтыг архивын эх баримттай тулган шалгаж цахимжуулалтын явцад буруу цахимжуулсан, бүртгэлийн явцад буруу дутуу боловсруулсан 323 алдаа зөрчлийг жагсаалтаар гаргаж хяналтын улсын байцаагчид дүгнэлт гаргуулахаар хүргүүллээ.

Цахим сан дахь 510 хувийн хэргийг нягтлан шалгаснаас 200 хувийн хэргийн 254 алдаатай мэдээллийг жагсаалтаар гаргаж хяналтын улсын байцаагчид хүргүүлсэн.

Цахим сан дахь алдаатай 114 бүртгэлийн 138 зөрчилтэй мэдээлэл нотлох баримтанд хяналтын улсын байцаагчийн дүгнэлт үндэслэн засвар өөрчлөлт оруулж залрууллаа.

2021оны 3,4-р сард Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн газраас зохион байгуулсан цахим сургалтуудад тасгийн албан хаагчид бүрэн хамрагдлаа.

2021оны 5-р сард УБЕГ-аас зохион байгуулсан сонгуулийн итгэмжлэгдсэн ажилтны программын сургалтанд тасгийн бүртгэгч нар бүрэн хамрагдсан.

Монгол улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн итгэмжлэгдсэн ажилтнаар Эд хөрөнгийн тасгийн ахлах болон улсын бүртгэгч нар идэвхтэй, алдаа зөрчилгүй ажилласан.

Аймгийн төвийн Есөнбулаг сумын орлогч дарга, 8 багийн дарга, нийгмийн ажилтан нартай уулзалт хийж хаягжуулалтын хууль журмуудыг хэрэгжүүлэх, ИТХ-ын тогтоол шийдвэрийн талаар мэдээлэл солилцож уулзалт хийлээ.

Хариуцлагын даатгалд хамрагдах эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэгч нарын судалгааг ЭХЭУБГазарт хүргүүлэн, хариуцлагын даатгалын танилцуулга сургалтанд Эд хөрөнгийн эрхийн бүртгэгч нар хамрагдсан.

Эд хөрөнгийн 9393 хувийн хэргийг цахим системд тулган шалгаж цахимжуулаагүй орхигдсон Y-0508000041 дугаартай хувийн хэргийг нөхөн цахимжууллаа.

Хууль хяналтын байгууллагаас ирүүлсэн 213 албан бичгийн дагуу 382 иргэн хуулийн этгээдийн эд хөрөнгө өмчлөлтэй холбоотой лавлагаа олгож, 5 шүүхийн шийдвэрийн дагуу архивын нотлох баримтын хуулбар гаргаж, 15 үл хөдлөх эд хөрөнгийн захиран зарцуулах эрх түдгэлзүүлсэн тусгай тэмдэглэл бүртгэж, 15 эд хөрөнгийн захиран зарцуулах эрхийг сэргээсэн бүртгэл хийж, МИК-ийн 2 албан бичгийн дагуу 15 үл хөдлөх хөрөнгийн хөрөнгийн багц дахь тусгай тэмдэглэл бүртгэж, бусад төрийн байгууллагын албан бичгийн дагуу 3 лавлагаа мэдээлэл гаргаж тухай бүр хугацаанд нь хариу хүргүүлээ.

Иргэн хуулийн этгээдээс ирүүлсэн эд хөрөнгө өмчлөх эрхтэй холбоотой 10 өргөдөл хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэж хариу өгч ажиллалаа

### **Найм. ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН БҮРТГЭЛИЙН ЧИГЛЭЛЭЭР:**

Хуулийн этгээдийн бүртгэлийн чиглэлээр тайлант хугацаанд шинээр үүсгэн байгуулсан аж ахуйн нэгж, хуулийн этгээдийн бүртгэл 99 хийлээ.

Үүнд: ХХК-65, НҮТББ-6, ГҮТББ-2, Улсын төсөвт үйлдвэрийн газар-5, Төрийн байгууллага албан газар-6, Үйлдвэрчний эвлэлийн байгууллага -1, Хоршоо-2, Сан-1, нөхөрлөл -11, Холбоо-1 тус тус бүртгэсэн байна.

Тайлант онд хуулийн этгээдийн гэрчилгээ дахин олгосон бүртгэл-102, нэмэлт өөрчлөлтийн бүртгэл-9, Хуулийн этгээдийн салбар төлөөлөгчийн газрыг улсын бүртгэлд бүртгэж гэрчилгээ олгосон-6, Татан буугдсан бүртгэл -3 тус тус бүртгэсэн байна. Мөн лавлагааны бүртгэл-6, Хууль хяналтын байгууллагад дэлгэрэнгүй лавлагаа-6 тус тус олгож Улсын бүртгэлийн ерөнхий газраас ирсэн 3 хариутай бичгийн хариуг заасан хугацаанд нь хүргүүлэн ажиллалаа.

Үйлчилгээний орлогоор орон нутгийн төсвийн дансанд 7,334,000 төгрөгийг төвлөрүүллээ.

2021.04.08-нд Улсын бүртгэлийн ерөнхий газраас зохион байгуулсан Эрхийн улсын бүртгэлд тэмдэглэл хийх, хүчингүй болгох ,хуулийн этгээдийн улсын бүртгэлд хориг тавих, цуцлах бүртгэлд анаахарах асуудлууд сэдэвт онлайн сургалтанд хамрагдсан.

2021.06.17-нд Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн үйл ажиллагааг зохицуулж байгаа захиргааны хэм хэмжээний актад оруулсан нэмэлт өөрчлөлтүүд сэдэвт онлайн сургалтанд хамрагдсан.

2021 оны аж ахуйн нэгжийн тооллогын Аймгийн комисст орж ажиллан тооллогын ажлыг амжилттай гүйцэтгэлээ.

### **Ес. АРХИВЫН ЧИГЛЭЛЭЭР:**

#### **ЭД ХӨРӨНГИЙН АРХИВ:**

Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн хувийн хэрэг, эх нотлох баримтыг хууль журмын дагуу хүлээн авч архивт байршуулж байна.

Тайлант онд шинээр нээсэн үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлийн 305, газар өмчлөх эрхийн 113, нийт 418 хувийн хэргийг архивт хүлээн авч бүртгэл хөтлөн байршууллаа.

4242 ш хувийн хэргийн эх нотлох баримтыг бүртгэгч нараас хүлээн авч хувийн хэрэг тус бүрт хийсэн.

2020 оны 12 сарын 01-ны өдрийн байдлаар тус архивт газраас бусад үл хөдлөх хөрөнгийн 5100ш, газар өмчлөх эрхийн бүртгэлийн 4694ш, нийт-9794 ш хувийн хэрэг тус тус хадгалагдаж байна.

Одоогийн байдлаар тус архивт байнга хадгалах бүртгэлийн дэвтэр 203 х/н, түр хадгадагдах 142 дэвтэр хадгалагдаж байна.

#### **ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН БҮРТГЭЛИЙН АРХИВ:**

Хуулийн этгээдийн архивт 2021 оны 11 сарын байдлаар анхны бүртгэлийн 99 хувийн хэрэг шинээр хүлээн авч, бүртгэн архивт байршуулсан. Үүнд. УТҮГ 5,



ТББАГ 6, Нөхөрлөл 11, Холбоо 1, НҮТББ 6, ГҮТББ 2, Сан 1, Хоршоо 2, ХХК 65 тус тус бүртгэгдсэн байна. Тус архивт нийт 1327 хувийн хэрэг хадгалагдаж байна. Үүнд: Хоршоо-114, нөхөрлөл- 71, ХХК-737, ТӨХХК-1, ХК-2, ХМХ-3, ХЗХ- 12, ББСБ-1, БСБ-1, Сан-6, Шашны байгууллага-3, ҮЭБ-10, ОНӨААТҮГ-14, ТӨААТҮГ-1, ТББ-157, УТҮГ-187 /.

Тайлант онд хуулийн этгээдийн хувийн хэрэгт 135 эх нотлох баримтыг хүлээн авч хувийн хэрэг нь байршуулсан.

**ИРГЭНИЙ БҮРТГЭЛИЙН АРХИВ:**

Тус архивт 12 сарын 01-ны өдрийн байдлаар 4623 ширхэг ИУБ маягт хүлээн авч цагаан толгойн үсгийн дарааллаар галиглан сан тус бүрт байршууллаа.

2021 онд шилжин явсан 307 иргэний хувийн хэргийг архивын сангаас татан авч харъяа газарт нь хүргүүллээ.

Шилжин ирсэн 251 иргэний хувийн хэргийг хууль журмын дагуу хүлээн авч бүртгэл хөтлөн цагаан толгойн үсгийн дарааллаар галиглан архивт байршуулсан.

16 нас хүрч шинээр иргэний үнэмлэх авсан 829 иргэний хувийн хэргийг цагаан толгойн үсгийн дарааллаар галиглан хувийн хэргийн нэгдсэн санд байршуулав.

2020 онд бүртгэгдсэн ИГБББ-ийн анхан шатны баримт болон бүртгэлийн дэвтэр 104 хадгаламжийн нэгжийг хүлээн авч ИГБББ-ийн санд байршууллаа. ИГБББ санд нийт 1294 хадгаламжийн нэгж хадгалагдаж байна.

Иргэний баримтын архивт нийт 80.419 хадгаламжийн нэгж 2.357.833 ширхэг ХААТР маягт хадгалагдаж байна.

Мөн 151 иргэний хүсэлтээр архивын баримтаас төрөлт, гэрлэлт, нас баралтын лавлагаа шүүж архивын үйлчилгээг үзүүллээ.

**-АРХИВЫН ЧИГЛЭЛЭЭР БУСАД ХИЙГДСЭН АЖЛУУД:**

Иргэн, Эд хөрөнгө, хуулийн этгээдийн бүртгэлийн архивын хувийн хэргийн мэдээг сар бүр гаргаж УБТА-т заасан хугацаанд хүргүүлэн ажиллалаа.

УБЕГ-ын УБТАрхиваас ирсэн чиглэлийн дагуу устгах бичгийн түүвэр жагсаалт үйлдэн байгууллагын ББНШК-ын хурлаар оруулан хэлэлцүүлж санал хүргүүлсэн. Архивын баримтын тоо бүртгэлийг хөтөлж байнга, түр хадгалах хадгаламжийн нэгжийн жагсаалт, ХХНЖ зэргийг гарган ББНШК-ын хурлаар батлуулав. 2020 онд устгахаар ялгасан баримтуудыг УБЕГ-аас ирсэн зөвлөмжийн дагуу устгаж акт үйлдэн Улсын бүртгэлийн төв архивт хүргүүлсэн. Аймгийн Засаг Даргаас Улсын бүртгэлийн хэлтсийн архивын тоног төхөөрөмжийн шинэчлэлд зориулан 7.500.000 төгрөгний дэмжлэг үзүүлсэн бөгөөд архивын нягтаршуулсан шүүгээ 6 ширхэгийг Улаанбаатар хотын Лүндээочир ХХК-аас захиалан авч архивт



суурилууллаа. Тус хэлтсийн архивч С.Баянаа 2021 оны 04 сард Архивын Ерөнхий Газраас зохион байгуулсан мэргэшил дээшлүүлэх сургалтад хамрагдсан. УБЕГ-ын Тамгын газраас зохион байгуулсан “Галын аюулгүй байдлын хангах” д зориулсан сургалт, Аймгын ЗДТГазраас зохион байгуулсан “Архив албан хэрэг хөтлөлтийн тухай хууль” ийн сургалтад тус тус хамрагдсан.

### **Арав. БҮРТГЭЛИЙН ХЯНАЛТЫН ЧИГЛЭЛЭЭР:**

Тайлант онд бүртгэлийн үйл ажиллагаанд хяналт тавьж, зөрчил гарахаас урьдчилан сэргийлж, зөвлөгөө өгч ажиллаж ирлээ.

Хяналт шалгалтын ажлын 11 заалт бүхий төлөвлөгөөг гаргаж, хэлтсийн даргаар батлуулан хэрэгжүүлж ажиллаж байна. Төлөвлөгөөний дагуу иргэн, эд хөрөнгө, хуулийн этгээд, архивын лавлагаа олгосон бүртгэлд өдөр тутмын болон түүвэрчилсэн, төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг хийсэн. Төлөвлөгөөт шалгалт 14, төлөвлөгөөт бус шалгалт 5, өргөдөл санал гомдлын мөрөөр 155 удаа шалгалт хийж шалгалтын дүнг илтгэх хуудсын хамт Хэлтсийн даргад танилцуулж, Хяналт шалгалтын газраас ирүүлсэн чиглэлийн дагуу хийсэн шалгалтын дүнг тухай бүр нь хүргүүлж ажилласан.

Иргэн, эд хөрөнгө, хуулийн этгээдийн бүртгэл, улсын бүртгэлийн архивын лавлагаа олгосон нийт 2063 бүртгэлд хяналт тавьж, 325 бүртгэлийн зөрчлийг арилгаж ажиллалаа.

Иргэний улсын бүртгэлийн 1689 бүртгэлд хяналт тавьж, хяналт шалгалтаар илэрсэн 163 бүртгэлийн зөрчлийг арилгаж ажиллалаа. Төрсний, гэрлэсний, гэрлэлт цуцалсны, үрчилсний, овог, эцгийн нэр, нэр өөрчилсний, эцэг тогтоосны, нас барсны биеийн давхцахгүй өгөгдлийн, регистрийн дугаарын нийт 842 бүртгэл, иргэний үнэмлэхийн 486, шилжилт хөдөлгөөний 361 бүртгэлийг шалгасан.

Улсын бүртгэлийн Ерөнхий газрын даргын 2021 оны 03 дугаар сарын 02-ны өдөр баталсан удирдамж, Хяналт шалгалтын газрын даргын 8/1364 дугаар албан бичгээр ирүүлсэн үүрэг, чиглэлийн дагуу иргэний шилжин суурьших хөдөлгөөний 2021 оны 01 дүгээр сарын 02-ны өдрөөс 2021 оны 04 дүгээр сарын 09-ний өдрүүдийн нийт 361 бүртгэлд 5 удаа шалгалт хийж, эх нотлох баримтыг цахимаар татан авч шалгахад бүртгэлийн нотлох баримтын бүрдэл шаардлага хангахгүй, үйлчилгээний хураамжийг илүү төлүүлсэн зэрэг 9 зөрчлийг илрүүлж, холбогдох сумын бүртгэгчид чиглэл өгч нөхөж бүрдүүлүүлэн, биелэлтийг шалгаж, зөрчлийг арилгаж ажилласан.

Монгол улсын Ерөнхийлөгчийн сонгуультай холбогдуулан иргэний шилжилт хөдөлгөөний бүртгэл, шилжилт хөдөлгөөнийг түр зогсоох, сонгогчдын хэсэг оноолт, сонгогч шилжилт, сонгогчдын нэрийн жагсаалтад өөрчлөлт оруулах, сонгогчдын нэрийн жагсаалт хэвлэх үйл ажиллагаанд хяналт тавьж ажилласан.

Сонгогч шилжилт хөдөлгөөнд бүртгүүлсэн нийт 772 иргэний нотлох баримтуудын бүрдүүлбэр болон өөрчлөлтийн лавлагааг нэгбүрчлэн хянаж шалган, хянасан тухай тэмдэглэж ажилласан..

Сонгогч шилжилтээр бүртгүүлсэн 2 сонгогчийн шилжиж очсон хэсгийн дугаарыг буруу бүртгэсэн бүртгэлийг залруулсан 2 дүгнэлт гаргаж зөрчлийг арилгаж шийдвэрлэсэн.

Мөн сонгогчдын нэрийн жагсаалт хэвлэх, нэрийн жагсаалт хүргэх ажиллагаанд хяналт тавьж ажилласан.

Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн 194 бүртгэлд хяналт тавьж, 144 бүртгэлийн зөрчлийг арилгах шийдвэр гаргаж ажиллалаа.

Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн архивын цахимжилтын явцад эд хөрөнгийн хаяг буруу, дутуу оруулсан, барьцаалагчийг буруу оруулсан, зурган мэдээлэл ороогүй, бүртгэлийн төрлийг буруу сонгосон, огноог буруу оруулсан, үнэ бичээгүй, өмчлөгчийг буруу, дутуу оруулсан, үйлчилгээний төрлийг буруу сонгож цахимжуулсан, зурган мэдээлэл харагдахгүй байгаа, давхардуулсан, дутуу цахимжуулсан 119 бүртгэл; мөн бүртгэл хийх явцад барьцааны гэрээний үйлчилгээг бүртгэхдээ улсын бүртгэлийн дугаарыг буруу бүртгэсэн, зурган мэдээллийн сольж оруулсан, өмчлөгчийн нэр, хаягийг буруу бүртгэсэн, үйлчилгээний нэршлийг буруу бүртгэсэн 11 бүртгэл, улсын бүртгэлийн гэрчилгээг үрэгдүүлсэн 14 гэрчилгээг хүчингүйд тооцсон хяналтын байцаагчийн дүгнэлт гаргаж шийдвэрлэсэн.

Хуулийн этгээдийн бүртгэлийн 90 бүртгэлд хяналт тавьж, 12 бүртгэлийн зөрчлийг арилгаж ажилласан. Бүртгэлийн хувийн хэргийг хуулийн этгээдийн улсын бүртгэлийн цахим мэдээллийн сантай тулган шалгахад хуулийн этгээдийн эрх шилжүүлсэн өөрчлөлт мэдээллийн санд ороогүй 4, хувийн хэргийн дугаарлалт буруу 4, үүсгэн байгуулагч болон хувьцаа эзэмшигч гишүүний мэдээллийг оруулаагүй орхигдуулсан 4 зөрчил илэрснийг арилгаж шийдвэрлэлээ.

Архивын лавлагаа олгосон 95 бүртгэлд хяналт тавьсан.

Алтай, Баян-Уул, Бугат, Дарив, Дэлгэр, Тонхил, Төгрөг, Хөхморьт, Цогт, Цээл, Чандмань, Шарга, Эрдэнэ, Гуулин сумдын иргэний улсын бүртгэлийн үйл

ажиллагаанд төлөвлөгөөт шалгалтыг хийж, 845 бүртгэлийн нотлох баримтыг тулган шалгаж, 101 зөрчлийг шалгалтын явцад арилгуулж шийдвэрлэсэн.

Иргэдээс ирүүлсэн 23 өргөдөл, материалыг хүлээн авч, 16 өргөдлийг хуулийн хугацаанд шийдвэрлэсэн, 7 өргөдлийн хугацаа болоогүй, шийдвэрлэх шатандаа байна.

Улсын бүртгэлийн зөрчил арилгах, засвар өөрчлөлт оруулах, бүртгэл хүчингүй болгох, регистрийн дугаар өөрчлөх, цахим санд бүртгэл хийх, бүртгэл сэргээн тогтоосон 113 дүгнэлт гаргаж, дүгнэлтээр 206 бүртгэлийн зөрчлийг арилган, 486 иргэний үнэмлэхийн бүртгэлийг хүчингүй болгосон. Иргэний улсын бүртгэлийн чиглэлээр 67, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн 12, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн чиглэлээр 34 дүгнэлт гаргаж, Хяналт шалгалтын газраар хянуулан, биелэлтийг хангуулж ажилласан.

Бүртгэл хийх явцад зөрчил гаргасан 43 бүртгэлд холбогдох бүртгэгчээс тайлбар авч, зөрчлийг арилгасан.

Зөрчлийн талаарх гомдол мэдээллийг хүлээн авч, прокурорын байгууллагын гомдол мэдээллийн нэгдсэн бүртгэлд тухай бүрд нь бүртгүүлэн, зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааг эрхлэн явуулж, материалыг аймгийн Прокурорын газрын хяналтын прокурорт 5 хоног тутамд хүргүүлэн хянуулж ажиллаж байна. Тайлангийн хугацаанд улсын бүртгэлийн хууль тогтоомж зөрчсөн 206 хүнд нийт 4.120.000 төгрөгийн торгох шийтгэл ногдуулсан.

Хяналт шалгалтын ажлын статистик тоон мэдээг батлагдсан хүснэгтийн дагуу тухайн сарын 25-ны өдрөөр тасалбар болгон гаргаж, Хяналт шалгалтын газарт хүргүүлэн ажиллаж байна.

УБЕГ-аас зохион байгуулсан Сонгуулийн хуультай холбоотой сургалтанд танхимаар 1 удаа, Хяналтын улсын байцаагч нарын сургалтанд танхимаар 1 удаа, онлайнаар 3 удаа хамрагдсан.

### **Арван нэг. САНХҮҮГИЙН ЧИГЛЭЛЭЭР:**

#### **- Төсвийн орлогын төлөвлөгөөний гүйцэтгэл:**

2021 оны 11 сарын 30-ны өдрийн байдлаар тус хэлтэс нь 2021 онд бүртгэлийн үйлчилгээний орлогоор жилд 90.0сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлэх төлөвлөгөөтэйгээс 101.8 сая төгрөгний орлого төвлөрүүлж төлөвлөгөөний биелэлт 113% -тай байна.

-Төсөв, санхүү

2021оны 11-р сарын 30-ны өдрийн байдлаар 464,343,600.00төгрөгний урсгал санхүүжилт авч, 456,318,941.00 төгрөгийг зориулалтын даг уу төсвийн хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулах журмыг баримтлан зарцуулж ажилласан.

Төсвийн гүйцэтгэл, зарцуулалт /2021 оны 11-р сарын 30-ны өдрийн байдлаар/

ҮЗҮҮЛЭЛТ	Төлөвлөгө ө	Гүйцэтгэ л	Хэтрэлт, хэмнэлт
<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>464,343,60 0.00</b>	<b>464,343, 600.00</b>	<b>0.00</b>
Улсын төсвөөс санхүүжих	464,343,60 0.00	464,343, 600.00	<b>0.00</b>
<b>УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>464,343,60 0.00</b>	<b>456,318, 941.00</b>	<b>8,024,659.0 0</b>
<b>Цалин, хөлсболоннэмэгдэлурамшуулал</b>	<b>387,349,30 0.00</b>	<b>384,931, 857.00</b>	<b>2,417,443.0 0</b>
Үндсэнцалин	310,176,80 0.00	304,760, 021.00	<b>5,416,779.0 0</b>
Нэмэгдэл	69,103,400 .00	72,968,0 49.00	- <b>3,864,649.00</b>
Унаахоолныхөнгөлөлт	8,069,100. 00	7,203,78 7.00	<b>865,313.00</b>
<b>Ажиллогччоостөлөхнийгмийнд аатгал</b>	<b>54,399,300 .00</b>	<b>49,831,1 16.00</b>	<b>4,568,184.0 0</b>
Нийгмийндаатгалыншимтгэл	40,175,200 .00	35,607,0 16.00	<b>4,568,184.0 0</b>
Тэтгэмжийндаатгал	3,556,300. 00	3,556,30 0.00	<b>0.00</b>
ҮОМШ-нийдаатгал	2,844,600. 00	2,844,60 0.00	<b>0.00</b>
Ажилгүйдлийндаатгал	711,700.00	711,700. 00	<b>0.00</b>
Эрүүлмэндийндаатгал	7,111,500. 00	7,111,50 0.00	<b>0.00</b>
<b>Байрашиглалттайхолтогтмолзар дал</b>	<b>6,143,100. 00</b>	<b>6,080,62 2.00</b>	<b>62,478.00</b>
Гэрэл, цахилгаан	54,800.00	0	<b>54,800.00</b>
Түлш, халаалт	352,300.00	281,872. 00	<b>70,428.00</b>
Цэвэр, бохирус	78,000.00	0	<b>78,000.00</b>
Байрнытүрээс	5,658,000. 00	5,798,75 0.00	<b>-140,750.00</b>
<b>Хангамж, барааматериалынзардал</b>	<b>10,400,500 .00</b>	<b>9,810,64 6.00</b>	<b>589,854.00</b>
Бичигхэрэг	4,323,200. 00	4,828,00 0.00	<b>-504,800.00</b>
Тээвэр, шатахуун	2,944,000. 00	610,000. 00	<b>2,334,000.0 0</b>
Шуудан, холбоо, интернэт	1,566,000. 00	1,405,95 1.00	<b>160,049.00</b>
Хогхаягдалзайлуулах, хортон	24,500.00	210,000. 00	<b>-185,500.00</b>
Багаүнэтэй, түргэнэлэгдэх,	1,542,800. 00	2,756,69 5.00	- <b>1,213,895.00</b>
<b>Эдхогшил, урсгалзасварынзардал</b>	<b>2,575,000. 00</b>	<b>2,393,50 0.00</b>	<b>181,500.00</b>
Багаж, техник, хэрэгсэл	1,175,000. 00	1,175,00 0.00	<b>0.00</b>

Хөдөлмөрхамгааллынхэрэглэл	1,125,000.00	1,125,000.00	0.00
Урсгалзасвар	275,000.00	93,500.00	181,500.00
<b>Томилолт, зочнызардал</b>	<b>211,200.00</b>	<b>138,000.00</b>	<b>73,200.00</b>
Дотоодалбантомилолт	211,200.00	138000	73,200.00
<b>Бусдааргүйцэтгүүлсэнажил, үйлчилгээ</b>	<b>658,200.00</b>	<b>658,200.00</b>	<b>0.00</b>
БусаднийтлэгАҮТХураамж	396,200.00	396,200.00	0.00
ДаатгалынҮйлчилгээ	120,000.00	120,000.00	0.00
Тээврийнхэрэгслийнтатвар	120,000.00	120,000.00	0.00
Тээврийнхэрэгслийнношилгоо	22,000.00	22,000.00	0.00
<b>Барааүйлчилгээнийбусадзардал</b>	<b>792,000.00</b>	<b>660,000.00</b>	<b>132,000.00</b>
Хичээлүйлдвэрлэлийндадлагахийх	792,000.00	660,000.00	132,000.00
<b>Холбоонысувагашигласныхөлс</b>	<b>1,815,000.00</b>	<b>1,815,000.00</b>	<b>0.00</b>
<b>Харилцахдансныэцсийнүлдэгдэл</b>	<b>0.00</b>	<b>8,024,659.00</b>	<b>8,024,659.00</b>

**- Өглөг, авлагын талаар:**

2021 онд цалин болон ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлийн зардал хүрэлцэхгүй байсан тул Санхүү аж ахуйн хэлтэст 2021.06.22-ны №528, 2021.10.19-ны №785 тоот албан бичгээр тооцоог гарган хүргүүлж санхүүжилтыг нэмж шийдвэрлүүлсэн.

Төсвийн гүйцэтгэл, зарцуулалтын хувьд баталсан төсвийн хуваарийн дагуу явж байгаа боловч зарим зардлуудад хувиарласан төсөв хүрэлцэхгүй байсан учир тооцоо, судалгаа гаргаж УБЕГ-н Санхүү аж ахуйн хэлтэст хүргүүлэн төсвийн хуваарьт 5 удаа өөрчлөлт оруулан зарим зардлуудыг өөр эдийн засгийн ангилал хооронд шилжүүлэн өглөг, авлагагүй ажиллаж байна.

**-Нэмэлт санхүүжилтын талаар:**

2021 оны Монгол Улсын Ерөнхийлөгчийн ээлжит сонгуультай холбоотойгоор УБЕГазраас нийт **82,097,000.00** төгрөгний санхүүжилт авч Итгэмжлэгдсэн ажилтнуудын урамшуулалд **49,100,100.00** төгрөг, бусад зардалд **32,996,900.00** төгрөг, нийт **82,097,000.00** төгрөгийг зориулалтын дагуу зарцуулсан.

Мөн Аймгийн Засаг Даргын 2021 оны А/275 тоот захирамжаар Сумдыг улсын бүртгэлийн онлайн системд холбоход дэмжлэг болгон **7,500,000.00** төгрөгийн санхүүжилтыг шийдвэрлэж өгснийг зориулалтын дагуу зарцуулсан.

**- Аудит, хяналт шалгалтын байгууллагаас хийсэн шалгалтаар зөрчил дутагдалгүй ажилласан байдал, НББОУС, холбогдох хууль тогтоомж, заавар, журам мөрдөж ажилласан байдал**

Санхүүгийн ил тод байдлыг хангах зорилгоор тус хэлтэс нь Говь-Алтай аймгийн Төрийн аудитын байгууллагаар 2020 санхүүгийн тайланд аудит хийлгэж “**ЗӨРЧИЛГҮЙ**” гэсэн дүгнэлттэй гарсан.

Мөн 2021 оны Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн Төрийн аудитын газар хяналт шалгалтаар зөрчилгүй илрээгүй болно.

**-Үндсэн хөрөнгийн бүртгэл, ашиглалт, хадгалалт, хамгаалалт, хөрөнгө оруулалт.**

2021 оны эхэнд барилга, авто машин, машин тоног төхөөрөмж, тавилга эд хогшил, програм хангамж гэсэн 5-н бүлгийн 180,412,146.00 төгрөгийн үндсэн хөрөнгө бүртгэлтэй байсан бөгөөд 2021.11.30-ны байдлаар 373,944,946.00 төгрөгийн үндсэн хөрөнгө бүртгэлтэй байна.

Бүгд Найрамдах Солонгос Улсын Олон улсын хамтын ажиллагааны байгууллага “Койка”-ийн санхүүжилтээр Улсын бүртгэлийн ерөнхий газарт хэрэгжүүлж буй “Улсын бүртгэлийн системийн үйл ажиллагааг дэмжих төсөл”-ийн хүрээнд 2021 оны 09-р сард тус хэлтсийн сумдын улсын бүртгэгч нарт нийт 144 ширхэг 188,187,810.00 төгрөгийн компьютер, принтер, скайнер, хурууны хээ уншигч, дижитал камер, камерийн хөл, камерийн санах ойн карт, тогтворжуулагч зэрэг тоног төхөөрөмжийг хүлээн авсан.

Тус хэлтэс нь орон сууцны 3 өрөө байртай ба одоогоор ямар нэг үйл ажиллагаа явагдаагүй байна.

Хэлтсийн албан хаагчдын хэрэглэж байгаа эд хөрөнгийн ашиглалтын бүртгэлийг хүн тус бүрээр хөтөлж байна.

Хэлтсийн даргын 2021 оны А/17 тоот тушаалаар үндсэн хөрөнгийн жилийн эцсийн тооллогыг хийж гүйцэтгэсэн.

**- Тайлан мэдээ**

2021 онд тус хэлтсийн сар, улирал, өдөр тутам гаргах тайлан, мэдээг хугацаанд нь гаргаж харъяалагдах байгууллагад хүргүүлж ажилласан.

Үүнд:

1. Тус хэлтсийн төсвийн гүйцэтгэлийн мэдээг сарын бүрийн 2-ны өдрийн дотор Төрийн сангийн хэлтсээр баталгаажуулан Санхүү төлөвлөлтийн газрын

нягтлан бодогч А.Наранцэцэгт [a.narantsetseg@burtgel.gov.mn](mailto:a.narantsetseg@burtgel.gov.mn) цахим шуудангаар хугацаанд нь хүргүүлсэн.

2. Үнэт цаасны тайлан мэдээг сар бүрийн 5-ны өдрийн дотор Санхүү төлөвлөлтийн газрын нягтлан бодогч Ц.Ганчимэгт [ts.ganchimeg@burtgel.gov.mn](mailto:ts.ganchimeg@burtgel.gov.mn) цахим шуудангаар хугацаанд нь хүргүүлсэн.

3. 2021 оны 1, 2, 3-р улирлын санхүүгийн тайланг дараа сарын 15-ны өдрийн дотор Санхүү төлөвлөлтийн газрын нягтлан бодогч А.Наранцэцэгт [a.narantsetseg@burtgel.gov.mn](mailto:a.narantsetseg@burtgel.gov.mn) цахим шуудангаар хугацаанд хүргүүлж, и-тайланд шивсэн.

4. Тус хэлтсийн нийгмийн даатгалын шимтгэлийн тайланг сар бүрийн 5-ны дотор бэлтгэн гаргаж Аймгийн Нийгмийн даатгалын хэлтэст хугацаанд нь хүргүүлсэн.

5. 1, 2, 3-р улирлын ХХОАТ-н тайланг гарган дараа сарын 15-ны өдрийн дотор Аймгийн Татварын хэлтэст хугацаанд нь хүргүүлсэн.

6. 2022 оны төсвийн төслийг 2021.07.20-ны өдрийн №566 тоот албан бичгээр Санхүү аж ахуйн хэлтэст хүргүүлсэн.

**-Төсвийн ил тод нээлттэй байх зарчим, шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангах чиглэлээр хийсэн ажил**

Байгууллагын үйл ажиллагаа болон төсөв, санхүүгийн гүйцэтгэлийг хэлтсийн байрны мэдээллийн самбарт тухай бүр байршуулсан.

Шилэн дансны мэдээллийг 12-р сарын 03-ны байдлаар 133 мэдээлэл хугацаанд нь оруулсан, хугацаа хоцорсон болон огт оруулаагүй мэдээлэл байхгүй бөгөөд 2020 оны 4-р улирал, 2021 оны 1, 2, 3-р улирлын мэдээллийг хугацаанд нь илгээсэн.

**-Бараа материалын бүртгэл хөтлөлт, тайлагнасан байдал**

• Няравын болон улсын бүртгэгч нарын үнэт цаасны тайланг хугацаанд гаргуулж нярваар нэгтгүүлэн тогтмол хянаж ажилладаг ба Улсын бүртгэгч нараас ирүүлсэн үнэт цаасны тайланд тусгагдсан хүчингүй болсон үнэт цаасыг сар бүр хүчингүй болгосон акт үйлдэн, ашиглагдахаа байсан нийт **1,880,597.00** төгрөгний үнэт цаас, маягтыг байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөлийн хурлаар хэлэлцэж уг шийдвэрийн дагуу хэлтсийн даргын 2021 оны А/16 тоот тушаалаар акталж, устган, данснаас хассан байна.

• Аж ахуйн материал, бичиг хэрэг, бэлэн бүтээгдэхүүн, бусад бараа материалын тайланг сар бүр нярваар гаргуулан хяналт тавьж ажиллалаа.

ХЯНАСАН:  
ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ УЛСЫН БҮРТГЭЛИЙН  
ХЭЛТСИЙН ДАРГА Г.ЧҮЛТЭМЖАМЦ

ТАЙЛАН БИЧСЭН:  
МЭДЭЭЛЭЛ ТЕХНОЛОГИЙН АЖИЛТАН Э.БААТАРСҮРЭН